

ГАЗРЫН ТОСНЫ БҮРТГЭЛ, ТООЦООНЫ ЖУРАМД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

Нээлттэй нийгэм форум, Төлсөн авсанаа нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвслээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.3¹ ба 62.4² дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах зорилгоор газрын тосны үйл ажиллагаатай холбоотой шинээр боловсруулж буй дараах дүрэм, журмын төслийг иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж, санал шүүмж авах хэлэлцүүлэг зохион байгууллаа. Үүнд:

1. Газрын тосны бүртгэл, тооцооны журам
2. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам
3. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм

2018 оны 3 дугаар сарын 16-ны өдөр болсон уг хэлэлцүүлэгт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газрын мэргэжилтнүүд, холбогдох дүрэм, журмын төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүд, ТАН эвслийн гишүүн төрийн бус байгууллагууд, Канад Улсын Засгийн газрын Мерит төслийн зөвлөх, мэргэжилтнүүд оролцлоо.

Хэлэлцүүлгийн явцад Газрын тосны бүртгэл, тооцооны журамд иргэний нийгмийн байгууллагуудаас өгсөн санал шүүмжийг нэгтгэн “Хуулийн шүүмж”-ийн энэхүү дугаарт гаргав.

Ерөнхий санал

Журмын төслийн 1.1-д журмын зорилгыг Газрын тосны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд газрын тостой холбогдсон үйл ажиллагааг бүртгэх, тооцох, тайлагнах арга зүйг тодорхойлох, зохицуулахад оршино” хэмээн тодорхойлжээ. Харин журмын төсөлд дээрх зорилгод хамаарахгүй буюу бүртгэл, тооцоо, тайлагнах арга зүйг тодорхойлохтой холбоогүй зарим заалтууд тусгагдсан байна. Тухайлбал, журмын төслийн 11 дүгээр бүлэгт давагдашгүй хүчин зүйлд хамаарах нөхцөл байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг тайлан, тооцоо, бүртгэлтэй шууд хамааралгүй зохицуулалт тусгасан нь журмын зорилго, хамрах хүрээнд нийцэхгүй байна.

Санал: Иймд журмын төслөөс 11 дүгээр бүлгийг бүхэлд нь хасах нь зүйтэй.

Журмын төслийн 3 дугаар бүлэгт агуулагдах нэр томъёоны тодорхойлолт нь Газрын тосны тухай хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний (БХГ) загварт³ дурдсан нэр томъёоны тодорхойлолттой давхардсан байна. Бусад хуулийн заалтыг давхардуулалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийсэн байх нь захиргааны хэм хэмжээний актад тавигдах үндсэн шаардлагын нэг юм.⁴

1 Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.3.4. Энэ хуулийн 62.2-т зааснаас гадна дараах хүрээнд хэлэлцүүлэг хийж болно: Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд.

2 Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.4. Хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр зохион байгуулж болно: Уулзалт, ярилцлага

3 Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан тул хэм хэмжээ тогтоосон акт хэмээн үзнэ.

4 Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.8 дахь заалт

Санал: Иймд энэхүү журмын төслийн 3 дугаар бүлэгт заасан нэр томъёоны тодорхойлолтыг бүхэлд нь Газрын тосны тухай хууль, БХГ-ний загвартай харьцуулан шалгаж, давхардлыг арилгах шаардлагатай байна.

Журмын төсөлд хэрэглэсэн “хамаарал бүхий этгээд” хэмээх нэр томъёо нь Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд заасан “хамаарал бүхий этгээд” хэмээх тодорхойлолттой давхцан эргэлзээ үүсгэхээр байна. Учир нь тус хуулийн 99 дүгээр зүйлд заасан “хамаарал бүхий этгээд”-ийн тухай ойлголт нь эзэмшлийн хамаарал бүхий хуулийн этгээдээс гадна тэдгээрийн удирдах албан тушаалтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүн, төрөл, садны хүнийг багтаасан өргөн агуулгатай ойлголт юм.⁵

Санал: Журмын төслийн 3.9-д заасан “харилцан хамаарал бүхий этгээд”-ийн тодорхойлолтыг Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан компанийн эзэмшлийн хамаарал, түүний хууль зүйн тодорхойлолтод нийцүүлэх шаардлагатай байна.

Журмын төслийн 3.13-т заасан “хүргэлтийн цэг” гэсэн тодорхойлолт нь Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д заасан “хүргэлтийн цэг”-ийн тодорхойлолтоос зөрүүтэй байна. Түүнчлэн журмын төслөөр “хэмжилтийн цэг” хэмээх шинэ ойлголтыг санал болгосон нь Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д заасан “хүргэлтийн цэг” гэсэн ойлголттой агуулгын хувьд ижил байна. Журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн зүгээс дээрх хоёр ойлголтыг тусад нь, ялгаатайгаар тодорхойлох шаардлагатай хэмээн тайлбарлаж байгаа боловч ямар ч тохиолдолд захиргааны хэм хэмжээний актад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг зөрчсөн заалт тусгаж болохгүй юм.⁶ Энэ нь өөрөө тухайн захиргааны хэм хэмжээний актын хүчин төгөлдөр байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Санал: Иймд журмын төслийн 3.13 дахь заалтыг Газрын тосны тухай хуульд нийцүүлэн тодорхойлж, харин энэ чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай бол холбогдох эрх бүхий байгууллагад саналыг тусад нь уламжлах нь зохистой.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа нь газрын тосны хайгуулын үе шатаас эхлээд бүтээн байгуулалт, олборлолт зэрэг бусад бүх үе шатанд хэрэгжиж, хаалт буюу татан буулгалтын үед бүрэн хийгдэж дуусдаг цогц үйл ажиллагаа юм. Гэтэл журмын төсөлд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг зөвхөн татан буулгалтын үе шаттай холбон тодорхойлсон нь буруу байна. Үүнээс шалтгаалан газрын тосны үйл ажиллагааны хайгуул, бүтээн байгуулалт, олборлолтын үйл ажиллагааны явц дахь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал, тэдгээрийг тооцон бүртгэх, тайлагнах арга зүйг орхигдуулсан байна.

Санал: Иймд газрын тосны үйл ажиллагааны бүх үе шатны зардалд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой зардлыг тодорхойлон, түүнийг бүртгэх, тайлагнах арга зүйг журмын төсөлд нэмж тусгах шаардлагатай.

2015 оноос өмнө байгуулагдсан БХГ-ний дагуу санхүү, бүртгэл тооцоотой холбоотой тодорхой мэдээллийг нууцлах шаардлагатай боловч Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Байгууллагын нууцын тухай хуулиудаар⁷ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаатай холбоотой мэдээ тайланг нийтэд ил тод болгохыг шаарддаг.

Санал: Иймд энэхүү журмын төсөлд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнд тусгагдсан зардал, тэдгээрийн зарцуулалттай холбоотой санхүү, бүртгэлийн мэдээллийн тод байдлыг хангах зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй.

⁵ Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйл.

⁶ Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт

⁷ Байгууллагын нууцын тухай хуулийн 6 дугаар зүйл

Тусгай санал, шүүмж

Зүйл заалтын дугаар	Санал, шүүмж	Тайлбар үндэслэл
3.1	“Үр ашигтай нээлт гэж Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т заасныг” гэж өөрчлөх	Хуульд нийцүүлэх
3.4	“Хайгуулын ажлын зардал гэж Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27-д заасныг” гэж өөрчлөх	Хуульд нийцүүлэх
3.5	“Бүтээн байгуулалтын зардал гэж Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-д заасныг” гэж өөрчлөх	Хуульд нийцүүлэх
3.6	“Татан буулгалтын зардал гэж Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30-д заасныг” гэж өөрчлөх	Хуульд нийцүүлэх
3.8	“Өртөг нөхөгдөх зардал гэж Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.31-д заасныг” гэж өөрчлөх	Хуульд нийцүүлэх
3.12	“хяналтын цэг гэж Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгчийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний 2.1.4-т заасныг” гэж өөрчлөх	Хүчин төгөлдөр эрх зүйн акт буюу Засгийн газрын тогтоолоор батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэх
3.16	“баррель гэж Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгчийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний 2.1.5-д заасныг” гэж өөрчлөх	Хүчин төгөлдөр эрх зүйн акт буюу Засгийн газрын тогтоолоор батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэх
3.17	“Татан буулгалтын төлөвлөгөө гэж Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгчийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний 2.1.6-д заасныг” гэж өөрчлөх	Хүчин төгөлдөр эрх зүйн акт буюу Засгийн газрын тогтоолоор батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэх
3.18	“гэрээ байгуулсан өдөр гэж Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгчийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний 2.1.7-д заасныг” гэж өөрчлөх	Хүчин төгөлдөр эрх зүйн акт буюу Засгийн газрын тогтоолоор батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэх
3.19	“гэрээт жил гэж Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгчийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний 2.1.8-д заасныг” гэж өөрчлөх	Хүчин төгөлдөр эрх зүйн акт буюу Засгийн газрын тогтоолоор батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэх
3.20	“гэрээт талбай гэж Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгчийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний 2.1.9-д заасныг” гэж өөрчлөх	Хүчин төгөлдөр эрх зүйн акт буюу Засгийн газрын тогтоолоор батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэх
3.21	“талбай буцааж өгөх гэж Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгчийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний 2.1.10-т заасныг” гэж өөрчлөх	Хүчин төгөлдөр эрх зүйн акт буюу Засгийн газрын тогтоолоор батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэх

3.25	“хуанлийн сар гэж Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгчийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний 2.1.15-д заасныг” гэж өөрчлөх	Хүчин төгөлдөр эрх зүйн акт буюу Засгийн газрын тогтоолоор батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэх
3.26	“хуанлийн улирал гэж Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгчийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний 2.1.16-д заасныг” гэж өөрчлөх	Хүчин төгөлдөр эрх зүйн акт буюу Засгийн газрын тогтоолоор батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэх
3.27	“хуанлийн жил гэж Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгчийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний 2.1.7-д заасныг” гэж өөрчлөх	Хүчин төгөлдөр эрх зүйн акт буюу Засгийн газрын тогтоолоор батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэх
3.28	“санхүүгийн жил гэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасныг” гэж өөрчлөх	Хүчин төгөлдөр эрх зүйн акт буюу Засгийн газрын тогтоолоор батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэх
4.9.2.11	“алданги гэсний дараа хохирлын нөхөн төлбөр” гэж нэмэх	Гэрээлэгчийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй, ялангуяа байгаль орчныг хамгаалах талаар хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас байгаль орчин, иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлын нөхөн төлбөр нь өртөг нөхөгдөх зардалд тооцогдох ёсгүй.
11 дүгээр бүлэг	Уг бүлгийг бүхэлд нь хасах	<ul style="list-style-type: none"> • Тус бүлэгт тусгагдсан заалтууд нь энэхүү журмын төслийн 1.1-д заасан зорилгод хамаарахгүй буюу бүртгэл, тооцоо, тайлагнах арга зүйтэй холбоогүй байна. • Газрын тосны тухай хууль, БХГ-ний зохицуулалттай давхардсан байна. • Гэрээлэгчийг БХГ-ний дагуу төлөх төлбөр урамшуулаас чөлөөлөхөөр заасан нь Газрын тосны тухай хууль, БХГ-ний заалтыг зөрчсөн байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалтыг зөрчиж байна. • Журмын төслийн 11.8-д гэрээлэгчийн үйл ажиллагаатай холбоотой орон нутгийн захиргааны болон ИТХ-ын аливаа шийдвэрийг орон нутгийн эсэргүүцэл буюу хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг зогсоох үндэслэл гэж үзэхээр заажээ. Энэ нь нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг зөрчих буюу хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт шалгалт хийж, зөрчлийг таслан зогсоох, арилгуулах арга хэмжээ авах боломжийг алдагдуулахаар байна.

Дугаарыг эрхэлсэн: Д.ЭРДЭНЭЧИМЭГ

ННФ-ын Эдийн засгийн хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn

